



ГАДААД ХУДАЛДААНЫ САРЫН ТОЙМ*

2020 оны 2 дугаар сар


Ерөнхий тойм: Энэ оны эхний 2 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 21%-иар буюу 410 сая ам.доллараар буурч 1,521 сая ам.доллар байв. Үүнд экспорт 30%-иар буюу 323 сая ам.доллараар, импорт 10%-иар буюу 87 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 235 сая ам.доллараар буурч 21 сая ам.долларын ашигтай гарлаа.

Хүснэгт 1. Гадаад худалдааны гүйцэтгэл /сая ам.доллар/


Төрөл	Жилээр			Өөрчлөлт				Эхний 2 сар			Өөрчлөлт			
	2017	2018	2019	2018/2017		2019/2018		2018	2019	2020	2019/2018		2020/2019	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	10,536	12,887	13,747	2,351	22%	860	7%	1,564	1,931	1,521	367	23%	(410)	-21%
Экспорт	6,201	7,012	7,620	811	13%	608	9%	838	1,094	771	255	30%	(323)	-30%
Импорт	4,335	5,875	6,127	1,540	36%	252	4%	726	838	750	111	15%	(87)	-10%
Тэнцэл	1,865	1,137	1,492	(728)		356	31%	112	256	21	144	128%	(235)	-92%

Валютын төлбөртэй худалдааны тэнцэл** 2020 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 62 сая ам.доллараар буурч 88 сая ам.долларын ашигтай гарсан байна.

Зураг 1. Валютын төлбөр (ВТ)-тэй худалдаа /3 сарын гулсах дундаж/




Зураг 2. Худалдааны тэнцэл, голлох түнш орнуудаар



Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 56% буюу 847 сая ам.долларын худалдааг БНХАУ-тай, 19% буюу 289 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 13%-иар өссөн бол БНХАУ-тай хийсэн худалдаа 21%-иар буурлаа.

Зураг 3. Худалдааны нөхцөлийн индекс /3 сарын гулсах дундаж/



Гадаад худалдааны нөхцөлийн индекс 2020 оны 2 дугаар сард өмнөх оны мөн үеэс 1%-иар, өмнөх сараас 13%-иар буурч 1.661-д хүрлээ. Худалдааны нөхцөлийн индекс өмнөх сараас муудахад чулуун нүүрсний хилийн үнэ буурснаар тайлбарлагдаж байна.

*Энэхүү тоймыг ГЕГ-ын "Гадаад худалдааны барааны статистик мэдээлэл"-д үндэслэн, дэлхийн улс орнуудын Төв банкны практикт нийцүүлж, судалгаа шинжилгээний ажлын хэрэгцээнд зориулан боловсруулав.

** Нийт худалдааны дүнгээс дахин экспорт/импорт, боловсруулах бараа, бараа солилцоо, хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн бараа, гадаадын зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн бараа болон бусад барааг хассан дүн болно.

Экспорт 2020 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 30%-иар буюу 323 сая ам.доллараар буурав. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт буурсан нь нийт экспортыг 27 нэгж хувиар бууруулах чиглэлд нөлөөлөв. Уул уурхайн түүхий эдийн нийт экспортод эзлэх хувь өнгөрсөн оны мөн үеэс 0.2 нэгж хувиар өссөн бол мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын эзлэх хувь 0.3 нэгж хувиар буурсан байна.

Хүснэгт 2. Экспортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2018			2019			2020			Δ (2019/2018)			Δ (2020/2019)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
1. Уул уурхай		762	91%	1,018	1,018	93%		719	93%	256	34%	31%	(299)	-29%	-27%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	205	275	33%	229	309	28%	192	219	28%	34	13%	4%	(90)	-29%	-8%
1.2. Чулуун нүүрс	3,149	242	29%	4,025	332	30%	2,780	229	30%	(10)	37%	1%	(104)	-31%	-9%
1.3. Боловсруулаагүй нефть	1,010	63	7%	1,011	53	5%	288	17	2%	(10)	-15%	-1%	(36)	-68%	-3%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	932	40	5%	1,181	52	5%	1,427	99	13%	13	32%	2%	47	90%	4%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	1,696	72	9%	4,665	196	18%	1,556	80	10%	124	171%	15%	(116)	-59%	-11%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	21	37	4%	25	34	3%	26	36	5%	(3)	-7%	0%	1	3%	0%
1.7. Жош, лейцит, нефелин	49	16	2%	69	23	2%	82	20	3%	8	49%	1%	(3)	-13%	0%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	1	6	1%	1	8	1%	1	7	1%	2	35%	0%	(1)	-1%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	0	1	0%	0	0	0%	0	0	0%	(0)	-29%	0%	(0)	-94%	0%
1.10. Мөнгө /тонн/	0	0	0%	0	0	0%	0	0	0%	(0)	0%	0%	-	0%	0%
1.11. Бусад	106	11	1%	54	9	1%	22	12	2%	(2)	-17%	0%	3	36%	0%
2. Мал аж, ахуй	87	29	4%	72	32	3%	49	20	3%	2	7%	0%	(11)	-36%	-1%
2.1. Амьд мал, малын мах	5	11	1%	5	10	1%	1	2	0%	(1)	-12%	0%	(8)	-81%	-1%
2.2. Арьс, шир	80	5	1%	63	3	0%	46	2	0%	(2)	-38%	0%	(0)	-15%	0%
2.3. Малын өлөг гэдэс	0	1	0%	0	1	0%	0	1	0%	0	40%	0%	(0)	-20%	0%
2.4. Ноолуур	1	11	1%	1	12	1%	1	13	2%	1	12%	0%	1	11%	0%
2.5. Ноос, бусад үс, хялгас	1	2	0%	2	5	0%	1	1	0%	4	227%	0%	(4)	-76%	0%
2.6. Бусад	0	0	0%	0	0	0%	0	0	0%	(0)	-19%	0%	(0)	-56%	0%
3. Газар тариалан	1	0	0%	11	3	0%	5	2	0%	2	424%	0%	(1)	-34%	0%
4. Аж үйлдвэрлэл	11	47	6%	74	41	4%	29	30	4%	(5)	-11%	-1%	(12)	-29%	-1%
4.1. Хүнс	5	17	2%	6	15	1%	2	5	1%	(2)	-11%	0%	(10)	-69%	-1%
4.2. Ноолууран эдлэл	0	3	0%	0	6	1%	0	3	0%	3	82%	0%	(3)	-49%	0%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	1	2	0%	0	2	0%	1	2	0%	(1)	-37%	0%	0	23%	0%
4.4. Уул уурхай	4	17	2%	17	14	1%	4	14	2%	(3)	-19%	0%	(1)	-4%	0%
4.5. Цахилгаан, электрон бараа	0	0	0%	0	0	0%	0	0	0%	(0)	-26%	0%	(0)	-18%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	0	5	1%	0	4	0%	0	5	1%	(2)	-35%	0%	2	49%	0%
4.7. Бусад	0	1	0%	51	1	0%	23	1	0%	0	0%	0%	0	9%	0%
5. Бусад	0	0	0%	0	0	0%	0	0	0%	(0)	0%	0%	0	28%	0%
Нийт дүн		838		1,094			771			255	30%		(323)	-30%	

² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 3. Экспортын өөрчлөлт, 2020 оны эхний 2 сар

Төрөл	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
1. Уул уурхай	(311)		13		(299)	-29%
1.1. Зэсийн хүдэр, баяжмал	(42)	47%	(48)	53%	(90)	-29%
1.2. Чулуун нүүрс	(102)	99%	(1)	1%	(104)	-31%
1.3. Боловсруулаагүй нефть	(43)	118%	6	-18%	(36)	-68%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	17	36%	30	64%	47	90%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	(130)	113%	14	-13%	(116)	-59%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	2	223%	(1)	-123%	1	3%
1.7. Жош, лейцит, нефелин	3	-103%	(6)	203%	(3)	-13%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	1	-79%	(2)	179%	(1)	-11%
1.11. Бусад	(17)	-543%	20	643%	3	36%
2. Мал аж, ахуй	(19)	168%	8	-68%	(11)	-36%
2.1. Амьд мал, малын мах	(16)	201%	8	-101%	(8)	-81%
2.2. Арьс, шир	(1)	223%	1	-123%	(0)	-15%
2.4. Ноолуур	(0)	-13%	1	113%	1	11%
3. Газар тариалан	(2)	220%	1	-120%	(1)	-34%
4. Аж үйлдвэрлэл	(63)	527%	51	-427%	(12)	-29%
5. Бусад	0	58%	(0)	-27%	0	28%
Нийт дүн	(395)		72		(323)	-30%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тогтмол тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 4. Дэлхийн зах зээл дээрх уул уурхайн түүхий эдийн үнэ



2020 оны эхний 2 сард экспортын гадаад худалдааны тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 395 сая ам.доллараар буурсан бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 72 сая ам.доллараар өслөө. Чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 145 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 49 сая ам.доллараар тус тус буурав. Аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээний бууралтаас шалтгаалж 63 сая ам.доллараар буурсан бол үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 51 сая ам.доллараар өссөн байна.

Дэлхийн зах зээл дээрх 1 унц алтны дундаж үнэ 2020 оны 2 дугаар сард 1,596 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 21%-иар, өмнөх сараас 2%-иар өссөн байна. “А” зэрэглэлийн цэвэршүүлсэн зэс болон төмрийн хүдрийн дундаж үнэ тайлант сард харгалзан 5,688; 88 ам.долларт хүрч өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэс 10%-иар, төмрийн хүдэр 1%-иар буурсан, зэсийн үнэ өмнөх сараас 6%-иар, төмрийн хүдэр 8%-иар буурлаа. Чулуун нүүрсний экспортын хилийн үнэ 2 дугаар сард 72 ам.долларт хүрч өмнөх оны мөн үеэс 16%-иар, өмнөх сараас 14%-иар буурлаа.

Импорт 2020 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 10%-иар буюу 87 сая ам.доллараар буурав. Импортын 10 нэгж хувийн бууралтийг ерөнхий ангиллаар задалж үзвэл хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний бууралт 7 нэгж хувийг, хэрэглээний бүтээгдэхүүний бууралт 4 нэгж хувийг тус тус бүрдүүлж байна.

Хүснэгт 4. Импортын гүйцэтгэл /сая ам.доллар/

Төрөл	2018			2019			2020			Δ (2019/2018)			Δ (2020/2019)		
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөлт	% ²	Дүн	Өсөлт	% ²
Хэрэглээний бүтээгдэхүүн		209	29%		236	28%		206	28%	26	13%	4%	(29)	-12%	-4%
Түргэн эдэлгээтэй	137	115	16%	118	111	13%	127	115	15%	(4)	-3%	0%	4	4%	0%
Хүнс	64	81	11%	55	78	9%	59	79	11%	(3)	-4%	0%	2	2%	0%
Эм, тариа	0	14	2%	0	14	2%	0	16	2%	(1)	-4%	0%	2	15%	0%
Бусад түргэн эдэлгээтэй бараа	72	20	3%	63	20	2%	68	21	3%	0	0%	0%	0	2%	0%
Удаан эдэлгээтэй	22	94	13%	27	124	15%	30	91	12%	30	32%	4%	(33)	-27%	-4%
Гутал, хувцас, цүнх	7	10	1%	9	8	1%	12	8	1%	(1)	-14%	0%	(0)	-2%	0%
Гэр ахуйн цах.хэрэгсэл ба тавилга	7	18	2%	8	16	2%	8	15	2%	(2)	-9%	0%	(1)	-8%	0%
Авто машин, түүний сэлбэг хэрэгсэл	0	55	8%	0	89	11%	0	58	8%	34	61%	5%	(31)	-35%	-4%
Бусад удаан эдэлгээтэй бараа	7	11	2%	9	11	1%	10	10	1%	(1)	-5%	0%	(1)	-5%	0%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	243	242	33%	188	334	40%	180	271	36%	91	38%	13%	(63)	-19%	-7%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	3	155	21%	4	257	31%	4	203	27%	102	66%	14%	(54)	-21%	-6%
Судлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	0	48	7%	1	95	11%	1	68	9%	47	99%	6%	(26)	-28%	-3%
Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	3	107	15%	3	163	19%	3	135	18%	55	52%	8%	(28)	-17%	-3%
Барилгын материал	47	51	7%	60	57	7%	60	46	6%	6	12%	1%	(11)	-19%	-1%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	5	37	5%	3	20	2%	3	22	3%	(17)	-46%	-2%	2	9%	0%
Аж үйлдвэрлэлийн орц	236	115	16%	300	86	10%	283	89	12%	(30)	-26%	-4%	4	4%	0%
Хүнсний орц	71	27	4%	4	2	0%	11	4	0%	(25)	-91%	-3%	1	44%	0%
Химийн бүтээгдэхүүн	29	16	2%	32	17	2%	29	13	2%	1	5%	0%	(3)	-20%	0%
Даавуу, утас, арьс, савхин эдлэл	7	3	0%	16	5	1%	10	4	1%	1	37%	0%	(1)	-15%	0%
Цахилгаан эрчим хүч	0	23	3%	0	14	2%	0	25	3%	(9)	-39%	-1%	11	80%	1%
Металлын хүдэр, баяжмал болон хаягдал	0	0	0%	0	0	0%	0	0	0%	(0)	-60%	0%	0	116%	0%
Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай	135	45	6%	136	48	6%	129	43	6%	2	5%	0%	(5)	-10%	-1%
Нефтийн бүтээгдэхүүн	236	157	22%	300	181	22%	283	183	24%	24	15%	3%	1	1%	0%
Дизель тулш	151	97	13%	181	111	13%	163	104	14%	14	14%	2%	(7)	-6%	-1%
АИ-92, АИ-95	47	33	5%	86	47	6%	72	46	6%	14	42%	2%	(1)	-2%	0%
А-80 болон бусад	39	27	4%	33	23	3%	47	33	4%	(4)	-14%	-1%	9	39%	1%
Бусад	4	1	0%	1	1	0%	3	1	0%	(0)	-20%	0%	(0)	-37%	0%
Нийт дүн		726		838		750		111	15%				(87)	-10%	

%² - Нийт өсөлтөд оруулсан хувь нэмэр (contribution to growth)

Хүснэгт 5. Импортын өөрчлөлт, 2020 он эхний 2 сар

Төрөл*	Тоо хэмжээний өөрчлөлт		Үнийн өөрчлөлт		Нийт өөрчлөлт	
	Тоо хэмжээний өөрчлөлт	%	Үнийн өөрчлөлт	%	Нийт өөрчлөлт	%
Хэрэглээний бүтээгдэхүүн	(25)	84%	(5)	16%	(29)	-12%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	(6)	9%	(57)	91%	(63)	-19%
Аж үйлдвэрлэлийн орц	7		(4)		4	4%
Нефтийн бүтээгдэхүүн	(10)	-7.24%	11	8.24%	1	1%
Дизель тулш	(11)	16.2%	4	-6.2%	(7)	-6%
АИ-92, АИ-95	(9)	10.07%	8	-9.07%	(1)	-2%
А-80 болон бусад	10	10.8%	(1)	-8%	9	3.9%
Бусад	1		(1)		(0)	-3.7%
Нийт дүн	(32)	37%	(55)	63%	(87)	-10%

* Ижил зориулалттай боловч харилцан адилгүй шинж чанартай бараа бүтээгдэхүүнүүд 1 ангилалд багтдаг тул дээрх тооцоолол нь зөвхөн ерөнхий хандлагыг харуулах тойм тооцоолол болохыг анхаарна уу.

Зураг 5. Импортын бүтээгдэхүүний жилийн өсөлт /3 сарын гулсах дундаж/



2020 оны эхний 2 сарын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 63 сая ам.доллараар, хэрэглээний бүтээгдэхүүний импорт 29 сая ам.доллараар буурсан бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний импорт 4 сая ам.доллар, нефтийн бүтээгдэхүүний импорт 1 сая ам.доллараар өссөнөөр нийт импорт 87 сая ам.доллараар буурлаа.

Нефтийн бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2020 оны 2 дугаар сард өмнөх оны мөн үеэс 7 хувиар, өмнөх сараас 0.2 хувиар тус тус өсч тонн тутамд 647 ам.долларт хүрэв.